

БАТЛАВ.
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА
Ж.АЛДАРЖАВХЛАН

2021 оны ... сарын ...-ны өдөр

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2021 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго. Авлигын эсрэг хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сурталчлах, Хан-Уул дүүргийн үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагуудад авлига, ашиг сонирхол, хүнд суртал үүсэх нөхцөл, эрсдэлийг бууруулж, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, ил тод, нээлттэй үйл ажиллагааг эрчимжүүлэх, бэхжүүлэх, олон нийтийн эрх ашгийг дээдэлж, албан хаагчдад шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, авлигаас ангид байлгахад оршино.

Д/д	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн үзүүлэлт
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх үйл	1.1. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг боломжит хэлбэрүүдээр олон нийтэд хүргэсэн байх.	Баримтжуулж, үр дүнг тооцон тайлагнасан байх.
		1.2. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах.	Үр дүнг тайлагнасан байх.
		1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэмшилд 110" мэдээллийн самбарыг байршуулах.	Мэдээллийг байршуулсан байх.
2	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах	2.1. Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг АТГ-ын сургалтын төлөвлөгөөнд тусгуулахаар хүргүүлсэн байх.	Сургалтад хамруулах санал өгсөн байх.
		2.2. АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад алба хаагчдаа хамруулсан байх.	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо
		2.3. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан иргэд, хүүхэд залууст хүргэх шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүн тооцож, тайлагнасан байх.	-Сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан байх, -Хамрагдсан хүүхэд залуус, иргэдийн тоо

3	Авлигатай тэмцэх газраас гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх	3.1. Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, 3.2. Мөрдөгчийн мэдэгдэл, 3.3. Зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ.	Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайланг хүргүүлсэн байх.
4	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх	4.1. Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга уриа, аянд нэгдсэн байдал, 4.2. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх.	Байгууллагаас хэрэгжүүлж буй үйл ажиллагаа авлигаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх.
5	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	5.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх, үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх.	-Шинэ шийдэл, технологи нэвтрүүлэх замаар хүнд суртал чирэгдлийг багасгах зэрэг үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулсан байх
6	Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах	6.1. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-т, 6.2. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4- д, 6.3. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудас дээрээ байршуулж, иргэд олон нийтийг үзэж танилцах боломжоор хангах.	Хуулийн хэрэгжилтийг хангуулж, иргэдэд ойлгомжтой хүртээмжтэй байдлаар хүргэхэд анхаарсан байх
Нийт 6 чиглэлийн 15 арга хэмжээ			

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

С.ЭНХБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

ХҮНИЙ НӨӨЦИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Н.САРАНГУА

